



ГАН ХИЙЦ
ХУВЬЦААТ КОМПАНИ
БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ,
ХУДАЛДАА, БАРИЛГА УГСРАЛТ
2090988 Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг
7-р хороо, наран 18140 тоот өөрийн байр
Утас: 96002297, Факс 70182448
Web site: www.gankhiits.mn
E-mail: info@gankhiits.mn

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК-Д

2026.02.09 № 01/07
Танай - ны

Материал хүргүүлэх тухай

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийг үүгээр хүргүүлж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах шийдвэрүүдийг гаргав. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 10:00 цагт компанийн хурлын танхимд хуралдуулахаар шийдвэрлэж, хурлын товыг албан ёсоор мэдэгдэв.
 2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан алдагдалтай гарсан тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэв.
- Холбогдох материалыг хавсаргав.

ХҮНДЭТГЭСЭН,

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



М. ДАВААСҮРЭН
(МУ-ын зөвлөх инженер,
Аж үйлдвэрийн Гавьяат ажилтан)



ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДААНЫ
“ГАН ХИЙЦ”
ХУВЬЦААТ КОМПАНИ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 04-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.2 дугаар зүйл, компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02-р сарын 04-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 10-ны өдрийн 10:00 цагаас компанийн хурлын танхимд хуралдуулахаар зарласугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг баталсугай. Үүнд:
 - Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - Ногдол ашгийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг танилцуулах
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хавсралтын дагуу баталсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

М.ДАВААСҮРЭН

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

П.ТӨВСАНАА

Э.ДОЛГОРСҮРЭН

Ц.ХАНГАЙ

Б.ГАНТУЛГА

Б.ЭРДЭНЭБАЯР



С.МАРГАД-ЭРДЭНЭ



Д.ОЮУНЗУЛ



О.УУГАНЦЭЦЭГ

ТУЗ-ийн 2026 оны ¹дугаар тоот
тогтоолын хавсралт

**“ГАН ХИЙЦ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гүйцэтгэх ажлын утга	Хугацаа	Хариуцах хүн
1	Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгийн биржд хүргэх	2026-02.06	ТУЗ-ийн гишүүн О.Ууганцэцэг
2	Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр нийтлэх	2026.02.10	Ерөнхий нягтлан бодогч Х.Ариунсанаа
3	Олон нийтийн хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаар мэдээлэх /Өглөөний сонин, Өдрийн сонин, UBS телевиз, www.Gankhiits.mn www.mse.mn /	2026-02-09 Давтан зар 2026-02-23	ТУЗ-ийн гишүүн О.Ууганцэцэг
4	Хурлаар хэлэлцэх асуудлыг бэлэн болгох Үүнд: - Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах; - Ногдол ашгийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг танилцуулах - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсөв батлах - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан	2024-03-13	ТУЗ-ийн гишүүн О.Ууганцэцэг
5	Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг Үнэт цаас төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөс авч бэлтгэх	2026-02-25	ТУЗ-ийн гишүүн О.Ууганцэцэг
6	Хурлын байрыг бэлдэх	2026-04-10	Хүний нөөийн менежер С.Лхамцэрэн
7	Компанийн үйл ажиллагааны тайлан, компанийн засаглалын жилийн тайланг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлэх	2026.04.13	ТУЗ-ийн гишүүн О.Ууганцэцэг
8	Хурлын ирцийг бүртгэн, гишүүдэд хурлын материалыг тараан танилцуулах	2026-04-10	Тооллогын комисс
9	Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг бүрдүүлэн Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлэх	2026-04-13	ТУЗ-ийн гишүүн О.Ууганцэцэг



ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДААНЫ
“ГАН ХИЙЦ”
ХУВЬЦААТ КОМПАНИ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 04-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г Ногдол ашиг хуваарилах эсэх тухай Г

“Компанийн тухай” хуулийн 46.5, 46.6 дугаар зүйл, “Компанийн дүрэм”-ийн 10.5 дах заалт, компанийн ногдол ашгийн бодлогын 2.3 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02-р сарын 04-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ган хийц ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан 693,660,190 төгрөгийн алдагдалтай гарсан тул 2025 оны үйл ажиллагаанд ногдол ашиг хуваарилахгүйгээр тогтоосугай.
2. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Даваасүрэн-д даалгасугай.
3. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг зохих журмын дагуу эрх бүхий байгууллага болон олон нийтэд хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Даваасүрэн-д даалгасугай

ТУЗ-ИЙН ДАРГА

М.ДАВААСҮРЭН

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

П.ТӨВСАНАА

Э.ДОЛГОРСҮРЭН

Ц.ХАНГАЙ

Б.ГАНТУЛГА

Б.ЭРДЭНЭБАЯР

С.МАРГАД-ЭРДЭНЭ

Д.ОЮУНЗУЛ

О.УУГАНЦЭЦЭГ

**ГАН ХИЙЦ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026.02.04
13.00

Дугаар

Улаанбаатар хот

Ган хийц ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 13:00 цагт Ган хийц ХК-ийн ТУЗ-ийн даргын өрөөнд хурал эхлэв.

Оролцсон хүмүүс: ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн, ТУЗ-ийн гишүүд Б.Эрдэнэбаяр, О.Ууганцэцэг, С.Маргад-Эрдэнэ, Д.Оюунзул, Хараат бус гишүүд Э.Долгорсүрэн, П.Төвсанаа, Б.Гантулга, Ерөнхий нягтлан бодогч Х.Ариунсанаа нар оролцов.

Хэлэлцэх асуудал:

1. 2025 оны санхүүгийн тайлан /Компанийн тухай хууль 76 дугаар бүлгийн 76.1.11 дэх заалт/
2. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны тайлан
3. Ногдол ашиг тараах эсэх /Компанийн тухай хууль 46 дугаар зүйл/ 76,1,12
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тов гаргах КТХ 76.1.2
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг батлах КТХ 76.1.3

Хэлэлцсэн нь:

ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн: Энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдрийн хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн 8 гишүүн оролцож 88,8%-ийн ирцтэй байна.

Энэ удаагийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэхээр санал оруулж байна.

1. 2025 оны санхүүгийн тайлан /Компанийн тухай хууль 76 дугаар бүлгийн 76.1.11 дэх заалт/
2. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны тайлан
3. Ногдол ашиг тараах эсэх /Компанийн тухай хууль 46 дугаар зүйл/ 76,1,12
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тов гаргах КТХ 76.1.2
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг батлах КТХ 76.1.3

Хурлын дотоод журам танилцуулья.

1. 2025 оны санхүүгийн тайлан Ерөнхий нягтлан бодогч Х.Ариунсанаа,
 2. 2025 оны компанийн үйл ажиллагааны тайлан Гүйцэтгэх захирал С.Маргад-эрдэнэ
 3. Ногдол ашиг тараах эсэх ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн
 4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тов гаргах ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн
 5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн
- нар тус тус танилцуулна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2 цагт багтаан хуралдуулах саналтай байна. Гишүүд хэлэлцэх асуудал, дотоод журамаа батлах уу.
- Хуралд оролцсон гишүүдийн 100 хувиар батлав. (М.Даваасүрэн, П.Төвсанаа, Э.Долгорсүрэн, С.Маргад-эрдэнэ, Б.Гантулга, Б.Эрдэнэбаяр, О.Ууганцэцэг, Д.Оюунзул)

ХЭЛЭЛЦСЭН НЬ 1: 2025 оны санхүүгийн тайлан

СОНССОН НЬ: Ерөнхий нягтлан бодогч Х. Ариунсанаа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Та бүхэнд тарааж өгсөн материалыг танилцуулья. Агуулгын хүрээнд дараах байдлаар танилцуулна. Борлуулалтын орлогын гүйцэтгэл, ББӨртөгийн гүйцэтгэл, Удирдлагын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл, Ашиг, алдагдал, Өглөг, авлагын өсөлт, бууралт, дүгнэлт

Ган хийц ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгон тайлагнаж борлуулалтын орлого 948,3 сая төгрөг, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 738,8 сая төгрөг, нийт ашиг /алдагдал/ 209,5 сая төгрөг,

ерөнхий ба удирдлагын зардал 903,1 сая төгрөг, Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/ 639,6 сая төгрөг алдагдалтай, татварын дараах алдагдал 693,6 сая төгрөг болсон байна. Борлуулалтын задаргаа, хийсэн ажлын жагсаалт, удирдлагын зардал зэргийг танилцуулга дээрээ гаргаж харуулсан бөгөөд Санхүү байдлын тайлан, татварын тайлангуудыг харьцуулсан байдлаар үзүүлээ.

Эдгээрээс дүгнэж хархад дараах дүгнэлтийг гарсан.

1. Ган хийц ХК нь 2025 онд 693,6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. Алдагдалтай ажиллагаанд нөлөөлсөн гол хүчин зүйлс нь:

- Борлуулалтын орлого төлөвлөсөн түвшинд хүрээгүй буюу гүйцэтгэл 23,1%,
 - Нийт борлуулалтын орлогын 40,1%-ийг бүрдүүлэхээр төлөвлөсөн Үйлдвэрийн борлуулалтын орлогын гүйцэтгэл 34,5%,
 - Нийт борлуулалтын орлогын 44,4%-ийг бүрдүүлэхээр төлөвлөсөн Төслийн борлуулалтын орлогын гүйцэтгэл 0%
 - Борлуулсан бүтээгдэхүүний өртөгийн орлогод эзлэх хувь 77,91% буюу, төлөвлөсөн түвшнөөс 46,6%-иар өссөн зэрэг үзүүлэлтүүд алдагдалтай ажиллахад гол нөлөө үзүүлж байна.
 - Ерөнхий удирдлагын зардлын хувьд төлөвлөсөн түвшнөөс 16%-иар бууруулж ажилласан.
2. Үйлдвэрлэлийн борлуулалтын орлого гүйцэтгэл хангаагүй шалтгаан нь:
- МАКРО түвшний хувьд зах зээлийн нөхцөл байдал, төмөр хийц үйлдвэрлэлийн салбарын БНХАУ-аас өндөр хамааралтай байдал, улс төрийн нөхцөл байдал, татварын дарамт зэргээс,
 - МИКРО түвшний хувьд үйлдвэрлэлийн ашиглалтын зардал, ажиллах хүчний ур чадвар, хөдөлмөрийн бүтээмж, тоног төхөөрөмжийн хүчин чадал зэрэг гол нөөцүүд хангалтгүй байгаа нь нэгж бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөгийг өсгөж импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөх боломжийг хязгаарлаж байна.
3. Төслийн борлуулалтын орлого гүйцэтгэл хангаагүй шалтгаан нь:

Компани татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн их хэмжээний өртэй, банкин дахь харилцах дансуудаа хаалгасан зэрэг нь санхүүгийн үйл ажиллагааг эрсдэлд оруулж улсын болон хувийн хэвшлийн байгууллагаас зарласан тендер, худалдан авах ажиллагаанд оролцох боломжийг хязгаарлаж байна. Үүний улмаас борлуулалтын боломж хумигдаж, зах зээлийн байр суурь сулрах, цаашлаад орлогын эх үүсвэр буурах эрсдэл үүсэж байгаа тул уг асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх шаардлагатай байна.

ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн: Ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайлан танилцууллаа. Дараагийн хэлэлцэх асуудалаа орьё.

ХЭЛЭЛЦСЭН НЬ 2: Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан

СОНССОН НЬ: Гүйцэтгэх захирал С.Маргад-Эрдэнэ: 2023 оноос зургийн инженерээр ажиллаж эхлээд, 2025 оны 07 дугаар сараас гүйцэтгэх захиралаар ажиллаж байна. Энэ ажилласан хугацаанд харсан, хийсэн ажлын туршлагаасаа тайлан дээрээ тусгасан. Танилцуулгын зорилго: 2025 оны үйл ажиллагааг дүгнэх, 2026 оны ЗОРИЛГО, ЗОРИЛТЫГ танилцуулах, 2026 оны ЗОРИЛГО, ТӨСӨВ-ийг ТУЗ-аар батлуулах

Агуулга

1. Компаний одоогийн нөхцөл байдал
2. 2025 оны үйл ажиллагаа, гүйцэтгэл
3. 2025 оны зорилго хэрэгжээгүй гол асуудлууд
4. 2026 онд дэвшүүлж буй зорилго
5. 2026 оны зорилгыг хэрэгжүүлэх зорилтууд

Компанийн одоогийн байдал

✓ Үйл ажиллагаа:

- Төмөр хийц үйлдвэрлэл,
- Төмөр хийц угсралт,
- Барилгын зураг төсөл боловсруулах

✓ Жилийн орлого: дундаж орлого 1-3 тэрбум төгрөг

✓ Жилийн дундаж үйлдвэрлэлийн тоо хэмжээ: 100–150 тонн

Компанийн одоогийн байдал

1. Компанийн хүний нөөц бодлого хангалтгүй
2. Төслийн хэрэгжилтийг хангахад зарцуулсан зардалыг хэмжих хэмжүүр сул.
3. Зах зээл дэх өрсөлдөх чадвар, тогтмол харилцагч, хамтын ажилгааны бодлого байхгүй
4. Өмнөх удирдагуудын шийвэрүүдээс шалтгаалсан үр дагаварууд одоо ч компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөн хэвээр байна.

2025 оны гүйцэтгэл үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ 118 тонн, 693,6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.

2025 оны зорилго хэрэгжээгүй гол асуудал хүний нөөцийн тогтворжилт сул, тоног төхөөрөмжийн хүчин чадал хязгаарлагдмал, процесс, стандартын нэгдсэн систем дутмаг гэсэн асуудалууд байна.

Эрсдэлүүд захиалга тасалдах, ажилтан гарах, түүхий эдийн үнэ өсөх гэсэн эрсдэлүүд байна.

2026 ОНЫ ЗОРИЛГО: Чанарын менежементийн тогтолцоог нэвтрүүлж, суурь нөөцийн бүрдүүлэлтийг сайжруулах замаар санхүүгийн чадавхийг сайжруулна.

Ган хийц ХК-ийн суурь нөөц хүний нөөц, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, мэдлэг, ур чадварын нөөц, санхүүгийн нөөц зэргийг голлон анхааран ажиллана.

2026 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөө жилд 150-200 тонн төмөр хийц үйлдвэрлэх, сард 1-2 захиалга, улиралд 4-5 захиалга авдаг болно. Чанарыг хяналтыг сайжруулах, гагнууры стандарт тогтоох, ажилчдын хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулах зэрэгт анхаарч ажиллана.

Ерөнхий нягтлан бодогч Х. Ариунсанаа: Компанийн 2026 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийн та бүхэнд танилцуулж байна. Дараах байдлаар төлөвлөсөн.

2026 онд 200 тонн төмөр хийц үйлдвэрлэж, төмөр хийцийн борлуулалтын орлогыг 763,6 сая төгрөг, угсралтын борлуулалтыг 206 сая төгрөг, зургийн борлуулалт 9,6 сая төгрөг, Төслийн борлуулалт 5,6 тэрбум төгрөг, түрээсийн орлогыг 86,7 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 4,6 тэрбум төгрөгөөр, Захиргаа удирдлагын зардал 1,0 тэрбум төгрөг *Хавсралтаар холбогдох зардлын дэлгэрэнгүйг орууллаа.*

Дүгнэлт

1. 2026 оны төсвийн төлөвлөлтөд "Улаанбаатар хотын гэр хорооллын дулаан хангамжийг шинэчлэх 50,000 газан халаагуурын төсөл"-ийн хүрээнд 1,500 ширхэг шингэрүүлсэн хий, цахилгаан хосолсон зуухыг үйлдвэрлэн нийлүүлэх, мөн 3,500 зуухыг шингэрүүлсэн хий, цахилгаан хосолсон тоноглолд шилжүүлэн тоноглох ажлыг үндсэн зорилтот арга хэмжээ болгон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

2. Дээрхи төслийн орлого нь нийт борлуулалтын орлогын 84,1%-ийг эзлэж байгаа бөгөөд уг төслийг хэрэгжүүлснээр 2026 оны борлуулалтын орлого өмнөх онтой харьцуулахад 6 дахин өсөх төлөвтэй байна.

3. 2026 оны төсвийн төлөвлөлтөнд хүний нөөцийн чадварыг сайжруулж, ажилчдын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртөгийг өмнөх онтой харьцуулахад 8,1%-иар бууруулж төлөвлөсөн.

4. Зорилтот зах зээлийг тэлэх, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилтын хүрээнд удирдлагын зардлыг өмнөх онтой харьцуулахад 30%-иар өсгөж төлөвлөсөн.

5. Компаний мөнгөн хөрөнгийн нөөцийг тогтворжуулах зорилтын хүрээнд 2026 онд 149,9 сая төгрөгийн авлагыг барагдуулж компаний үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

6. Компаний төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд харилцагч байгууллага, хувь хүнд төлөх өглөгөөс 466,1 сая төгрөг, татварын өглөгийг 50% бууруулах буюу 608,2 сая, НДШ-ийн өглөгийн үлдэгдлийг бүрэн барагдуулахаар төлөвлөсөн.

7. Дээрхи зорилтуудын хэрэгжилтийн үр дүнд 2026 оны жилийн эцсийн байдлаар компаний ашигт ажиллагаа өмнөх онтой харьцуулахад 111,8%-иар өсөх төлөвтэй байна.

ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн: 2024 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд саналаа хэлнэ үү.

Гишүүн Б.Гантулга: Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд дээр танилцуулга, асуулт, санал гээд явбал зүгээр байдаг. Танилцуулга явж байхад дундуур нь асуулт явахаар танилцуулга сунжираад, 2 цаг төлөвлөсөн хугацаа дуусч байна. Зарчимаа бариад асуултууд асууя.

1. Борлуулагчийн тоо хэд байсан бэ. Мөн цалин урамшуулал хэд байдаг вэ.
2. Авлага өглөгийн тайлан дээр насжилт харагдахгүй байна. Насжилтийг заавал оруулж өгөх хэрэгтэй. Насжилтийг оруулж өгсөнөөр найдваргүй авлага болгох зохицуулалт байхгүй юу.
3. Элэгдэлийн зардал хэдэн хувь байгаа вэ.
4. Компаний хэмжээнд бохир болон цэвэр ашгийн маржин хэд байгаа вэ.

Ерөнхий нягтлан бодогч Х.Ариунсанаа: Авлага өглөгийн насжилтийн хувьд харилцан хамааралтай компаниудыг авлага өглөг бол урт хугацаатай 10 жилээс дээш гэх мэт, Найдваргүй авлагын хувьд нөөц байгуулагдсан байгаа. Дараагийн танилцуулгандаа насжилтийг тусгаж ажиллана. Элэгдэлийн зардал 127 сая байна. Борлуулагчийн орон тоо байхгүй. Инженерүүд үнийн санал өгч ажилладаг.

Гишүүн Б.Гантулга: Төлөвлөгөөтэй холбоотой асуулт байна. Төлөвлөгөө 6,7 тэрбум төгрөг гэсэн тоо хаанаас гаргаж ирсэн бэ. Нийт зах зээлийн танилцуулга явсангүй, 10 хувь гэдэг нь .

Ерөнхий нягтлан бодогч Х.Ариунсанаа: 2026 онд “Улаанбаатар хотын гэр хорооллын дулаан хангамжийг шинэчлэх 50,000 газан халаагуурын төсөл”-ийн хүрээнд 1,500 ширхэг шингэрүүлсэн хий, цахилгаан хосолсон зуухыг үйлдвэрлэн нийлүүлэх, мөн 3,500 зуухыг шингэрүүлсэн хий, цахилгаан хосолсон тоноглолд шилжүүлэн тоноглох ажлыг үндсэн зорилтот арга хэмжээ болгон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ 50,000-ийн 10 хувийг нь манайх авч үйлдвэрлэхээр тооцож, оруулсан.

2026 онд 200 тонн төмөр хийц үйлдвэрлэж, төмөр хийцийн борлуулалтын орлогыг 763,6 сая төгрөг, угсралтын борлуулалтыг 206 сая төгрөг, зургийн борлуулалт 9,6 сая төгрөг, Төслийн борлуулалт 5,6 тэрбум төгрөг, түрээсийн орлогыг 86,7 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн. Нийт борлуулалтын 6,7 тэрбумаар төлөвлөсөн.

ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн: 2026 оны төлөвлөгөөнд газан халаагуурын төсөлтэй холбоотой танилцуулга тавихаар холбогдоххун ирсэн байна. Энэ танилцуулгыг сонсоё.

Төслийг санаачлагч: 10 жил гэр хорооллын зуухыг цахилгаан, газаар халаах халаагуур хийсэн. Мөн зуухыг нэмэлт тоноглолоор тоноглож цахилгаан, газ болгох ажлыг туршиж явна. 10 жилийн хугацаанд 7 оюуны өмчийн патент баталгаажуулсан, монгол гэрийн зуухыг энэхүү халаалтаар тоноглож туршиж байна. Дэлгэрэнгүй танилцуулгыг та бүхэн бичлэгээр харна уу.

Гишүүн Э.Долгорсүрэн: борлуулсан бүтээгдэхүүний өртөгийн задаргаа алга байна үүн дээр анхаараарай. Санхүүгийн тайланг хэвлээд давхар хавсаргах хэрэгтэй байна.үндсэн хөрөнгийн элэгдэлийн зардлыг сайн харах хэрэгтэй.

Гишүүн Д.Оюунзул: Гүйцэтгэх захиралд 2025 онд ямар хүндрэл бэрхшээл үүссэн, хийсэн ажлууд болон зохион байгуулсан ажилд ямар хүндрэл байсан, цаашид хүндрэлүүдийг яаж шийдэх талаар тайлан дээрээ тусгаж ярих хэрэгтэй. Энэ талаар бодлоо хэлнэ үү.

Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх талаар ярьж байна. Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэхийн тулд компани мөнгө, хүн хүчтэй байх хэрэгтэй тэгэхээр ойрын төлөвлөгөөнөөс хассан дээр байх.

Гүйцэтгэх захирал С.Маргад-эрдэнэ: Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн их байсан. Өөрөө бүх ажилд оролцоод явсан. Инженер техникийн ажилтан ажлаас гарах асуудал их байсан. Хүн ажлаас гарахад дараагийн хүний нөөцийн бодлого дутуу,

Гишүүн Б.Гантулга: Шинэ залуу гүйцэтгэх захиралаа туслаад, чиглүүлмээр байна. ТУЗ-ийн хурал дээр гүйцэтгэх захиралдаа орон зай өгч, шийдвэр гаргах боломжуудыг өгөх, нөгөө талаар ТУЗ-ийн гишүүд дэгтэй, асуулт, саналаа дарааллааар нь хэлээд явдаг баймаар байна.

Гишүүн П.Төвсанаа: Гүйцэтгэх захирлын танилцуулгыг сонслоо. Нөхцөл байдалхүнд, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн их байсан компанийнхаа асуудлыг олж

харсан байна. 50,000 зуух хөтөлбөрт орохоор төлөвлөж байгаатай холбогдуулан танилцуулга илтгэлийг сайн тавих хэрэгтэй. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, халамжаас хөдөлмөрт шилжих, монгол хүний үнэлэмжийг нэмэгдүүлэх асуудлыг Засгийн газар их ярьдаг илтгэлийн гол санааг үүнтэй уялдуулах хэрэгтэй байна.

Гишүүн Д.Оюунзул: Цахилгаан зуухтай холбоотой санал байна. Цахилгаан зуухны төсөв, төлөвлөгөөг төмөр хийцийн үйл ажиллагаанаас тусад хүн хүч, завсар үйлчилгээ, угсралт суурилуулалт, маркетинг, борлуулалт гээд төлөвлөж гаргах нь зүйтэй.

- **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:** Ган хийц ХК-ийн 2026 онд 200 тонн төмөр хийц үйлдвэрлэж, төмөр хийцийн борлуулалтын орлогыг 763,6 сая төгрөг, угсралтын борлуулалтыг 206 сая төгрөг, зургийн борлуулалт 9,6 сая төгрөг, Төслийн борлуулалт 5,6 тэрбум төгрөг, түрээсийн орлогыг 86,7 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 4,6 тэрбум төгрөгөөр, Захиргаа удирдлагын зардал 1,0 тэрбум төгрөг батлав.

ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн: ТУЗ-ийн гишүүдэд өөр асуулт, санал хүсэлт байна уу. Байхгүй бол дараагийн асуудалдаа орьё.

ХЭЛЭЛЦСЭН НЬ 3: Ногдол ашиг тараах эсэх талаар

СОНССОН НЬ: ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн: Компанийн тухай хууль 47 дугаар зүйлийг дагуу ТУЗ ногдол ашиг тараах эсэх шийдвэр гаргана гэсэн заалтын дагуу шийдвэр гаргана. Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.6 заалтуудыг үндэслэн тооцож, 2025 оны Санхүүгийн тайлангийн үр дүнг хархад Ган хийц ХК нь 2025 онд 693.6 сая төгрөгийн алдагдалтай гарсан тул энэ жил ногдол ашиг тараахгүй гэсэн санал гаргаж байна. Хуралд оролцсон гишүүдийн 100 хувиар батлав. (М.Даваасүрэн, П.Төвсанаа, Э.Долгорсүрэн, С.Маргад-эрдэнэ, Б.Гантулга, Б.Эрдэнэбаяр, О.Ууганцэцэг, Д.Оюунзул)

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Ган хийц ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан 693,6 сая төгрөгийн алдагдалтай гарсан тул 2025 оны үйл ажиллагаанд ногдол ашиг тараахгүйгээр шийдвэрлэж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн-д даалгав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ 4: Хувьцаа эзэмшигчдийн хурлын тов гаргах.

СОНССОН НЬ: ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн: Компанийн тухай хуулийн 76.1.2 заалт болон Компанийн дүрмийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас дөрвөн сарын дотор буюу 5 дугаар сарын 01-ны дотор Төлөөлөн удирдах зөвлөл зарлан хуралдуулна гэсэн заалтын дагуу хувьцаа эзэмшигчийн хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 09:00 цагт зохион байгуулах саналтай байна. Үүнтэй уялдуулан хугацаанууд дараах байдлаар гарсан. Хавсралтаар харуулав. Компанийн тухай хууль болон Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу хурлын тов гарсантай холбогдуулан хугацаануудыг тооцож оруулсан. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах хугацаа: 2026.02.09 UBS телевиз, Хөрөнгийн биржийн сайт, Ган хийц ХК-ийн сайт, давтан зар 2026.02.24-ны өдөр дахин зарлахаар төлөвлөсөн. Хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдрийг 2026.02.26 өдрөөр тасалбар болгон, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс албан бичиг хүргүүлж авна.

ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн: Эдгээр хугацаануудыг гишүүд дэмжиж байна. Саналаа хэлээрэй. Хуралд оролцсон гишүүдийн 100 хувиар батлав. (М.Даваасүрэн, П.Төвсанаа, Э.Долгорсүрэн, С.Маргад-эрдэнэ, Б.Гантулга, Б.Эрдэнэбаяр, О.Ууганцэцэг, Д.Оюунзул)

ТУЗ-ийн гишүүн О.Ууганцэцэг: Компанийн тухай хуулийн 67.1 заалт, Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу тооллогын комисс гишүүдийг томилж өгнө үү.

ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн: Хэлэлцэх асуудалтай холбоогүй хүмүүсийг тооллогын комиссын гишүүдээр томилоно. Дараах хүмүүсийг санал оруулж байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер Т.Буяннэмэх, Хүний нөөцийн менежер С.Лхамцэрэн, инженер З.Алтанхуяг нарыг сонгох саналтай байна.

Хуралд оролцсон гишүүдийн 100 хувиар батлав. (М.Даваасүрэн, П.Төвсанаа, Э.Долгорсүрэн, С.Маргад-эрдэнэ, Б.Гантулга, Б.Эрдэнэбаяр, О.Ууганцэцэг, Д.Оюунзул)

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 10-ны өдрийн 10:00 цагаас компанийн хурлын байранд хуралдуулахаар шийдвэрлэв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ 5: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал

СОНССОН НЬ: ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр санал оруулж байна. Компанийн тухай хуулийн 62.1.9, 62.1.13, 62.1.7 заалтуудын дагуу асуудлуудыг хэлэлцэх асуудалд оруулахаар болсон.

- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

- Ногдол ашгийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг танилцуулах

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсөв батлах

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан

ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн: Хэлэлцэх асуудал дээр нэмэх саналтай гишүүд байна уу. Саналаа хэлээрэй. Байхгүй бол санал хурааж батлая. Хуралд оролцсон гишүүдийн 100 хувиар батлав. (М.Даваасүрэн, П.Төвсанаа, Э.Долгорсүрэн, С.Маргад-эрдэнэ, Б.Гантулга, Б.Эрдэнэбаяр, О.Ууганцэцэг, Д.Оюунзул)

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Хувьцаа эзэмшигчдийн хуралд дараах асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.

- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

- Ногдол ашгийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг танилцуулах

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсөв батлах

ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн: Хэлэлцэх асуудал дууслаа. Хүрэлцэн ирсэнд баярлалаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 16:30 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга *Б. Алтаншагай* Б.АЛТАНШАГАЙ

Танилцсан:

ТУЗ-ийн дарга



М.ДАВААСҮРЭН

ГАН ХИЙЦ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Хурал хуралдах өдөр 2026.02.04

Цаг: 13:00 цагт

Хаяг : “Ган хийц” ХК-ний байранд

Хэлэлцэх асуудал :

1. 2025 оны санхүүгийн тайлан /Компанийн тухай хууль 76 дугаар бүлгийн 76.1.11 дэх заалт/
2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан /2025 оны Захиргаа аж ахуй болон үйлдвэрлэлийн зардлыг гүйцэтгэл/
3. Ногдол ашиг гараах эсэх /Компанийн тухай хууль 46 дугаар зүйл/ 76.1.12
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тов гаргах КТХ 76.1.2
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал КТХ 76.1.3

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

Хурал: Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

Хугацаа: 2026.02.04 13:00 цагт

Хурлыг нээж ТУЗ-ийн дарга М.ДАВААСҮРЭН үг хэлнэ.

1. 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН
 - Ерөнхий нягтлан бодогч Х.Ариунсанаа
 - Санал хүсэлт, дүгнэлт
2. 2025 ОНЫ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
 - Гүйцэтгэх захирал С.Маргад-эрдэнэ
 - Санал хүсэлт, дүгнэлт
3. НОГДОЛ АШИГ ТАРААХ ЭСЭХ
 - ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн
4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОВ ГАРГАХ
 - Хувьцаа эзэмшигчдийн хугацааг товлон,
 - Хэлэлцэх асуудлыг тогтоох
 - Тооллогын комиссын гишүүд сонгох

ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫГ ХУРАЛДУУЛАХ ТОВ ГАРГАХ

Хувьцаа эзэмшигчдийн хурал: 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах: КТ 62.1.9
2. Ногдол ашгийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг танилцуулах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлын төсөв батлах
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, түүнд хяналт тавих зохицуулалтын журам"-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр	Ган хийц ХК
Хаяг, утас	УБ хот СХД-ийн 7-р хороо Наран 18140-55 тоот
Хурал хуралдах өдөр, цаг	2026.04.10 10:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	УБ хот СХД-ийн 7-р хороо Ган хийц ХК байр, цахим
Хурлын төрөл:	Ээлжит
	ээлжит бус
Хурал зарлагч	ТУЗ
	ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн санал, шаардлага гаргасан /нэр/
	Саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан /нэр/
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2026.02.04
Олон нийтэд зарлах огноо	2026.02.09
Бүртгэх өдөр	2026.02.26
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2026.02.09
Хүргүүлсэн огноо	2026.02.06
Хурлын даргын нэр	М.Даваасүрэн
Тооллогын комиссийн дарга, гишүүдийн нэр	Дарга Т.Буяннэмэх, гишүүд С.Лхамцэрэн, З.Алтанхуяг
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/	Тогтоол, хурлын тэмдэглэл, хурлын зарын загвар, хурлын шийдвэр
Баримт, бичгийн хуудсын тоо	 ширхэг
	 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОММИССЫН ДАРГА

/С.МАРГАД-ЭРДЭНЭ /





2025 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлан

Боловсруулсан ажилтан: Х.Ариунсанаа


2026 ОН

АГУУЛГА:

1. Борлуулалтын орлогын гүйцэтгэл
2. ББӨртөгийн гүйцэтгэл
3. Удирдлагын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл
4. Ашиг, алдагдал
5. Өглөг, авлагын өсөлт, бууралт
6. Дүгнэлт

1. Борлуулалтын орлого /Төлөвлөгөө, гүйцэтгэлээр, өмнөх үетэй харьцуулснаар/


№	Борлуулалтын төрөл, ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь%,	Өмнөх он 2024	Өсөлт, бууралтын хувь, %
1	Борлуулалтын орлого /Үйлдвэрлэл/	1,641,818.18	567,656.57	34.57%	820,291.45	-30.80%
2	Борлуулалтын орлого/Угсралт/	492,545.45	251,240.01	51.01%	1,056,665.20	-76.22%
3	Борлуулалтын орлого/Зургийн ажил/	21,343.64	0.00	0.00%	12,654.55	-100.00%
4	Борлуулалтын орлого/Төслийн орлого/	1,818,181.82	0.00	0.00%	190,909.09	-100.00%
5	Борлуулалт- Түрээсийн орлого	117,309.09	97,174.70	82.84%	117,482.15	-17.29%
6	Бусад борлуулалт	0.00	32,274.03	100.00%	38,535.45	-16.25%
ДҮН		4,091,198.18	948,345.30	23.18%	2,236,537.89	-57.60%



2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг /Төлөвлөгөө, гүйцэтгэл, өмнөх үетэй харьцуулснаар/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь, %	Өмнөх он 2024	Өсөлт, бууралтын хувь, %
1	Борлуулалтын орлого	4,091,198.18	948,345.30	23.18%	2,236,537.89	-57.60%
2	ББӨртөг	2,173,872.91	738,840.70	33.99%	1,132,522.39	-34.76%
3	Орлогод эзлэх хувь, %	53.14%	77.91%	-	50.64%	-

24.7%



ББӨ-г орлогын 53.1% байхаар төлөвлөсөн, гүйцэтгэлээр орлогын 77.9% байна. Төлөвлөсөн түвшинтэй харьцуулахад 24,7%-иар, өмнөх үетэй харьцуулахад 27,7%-иар өссөн байна.




2.1 Үйлдвэрлэлийн зардал, ЗАА-г

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь, %	Өмнөх оны гүйцэтгэл	Өсөлт бууралт, %
1	Цалин, НДШ-ийн зардал	500,995.40	444,308.87	88.7%	496,331.65	-10%
2	Ашиглалтын зардал	39,905.72	42,234.45	105.8%	37,358.06	13%
3	Шуудан холбоо, дижитал платформын түрээсийн зардал	11,054.56	4,165.08	37.7%	12,426.88	-66%
4	Хүнс, хангамж, бичиг хэргийн зардал	44,276.62	35,806.33	80.9%	42,164.84	-15%
5	Түлш шатахуун, засварын зардал	29,763.27	16,855.56	56.6%	35,525.63	-53%
6	ХАБЭА-н зардал	24,037.73	0.00	0.0%	5,301.82	-100%
7	Чанарын хяналтын зардал	7,052.73	0.00	0.0%	316.73	-100%
8	Маркетингийн зардал	6,964.38	2,085.24	29.9%	1,110.00	88%
9	Сургалт, хүний нөөцийн үйл ажиллагааны зардал	4,080.00	1,010.00	24.8%	1,032.20	-2%
10	Урсгал засварын зардал	18,454.55	92.73	0.5%	26,497.39	-100%
11	Мэргэжлийн үйлчилгээний зардал	25,437.73	12,045.45	47.4%	23,950.09	-50%
12	Даатгалын зардал	5,524.02	0.00	0.0%	4,404.02	-100%
13	Төлбөр хураамжийн зардал	21,646.72	33,147.55	153.1%	22,931.27	45%
14	Баяр ёслол, нэгдсэн арга хэмжээний зардал	42,580.96	0.00	0.0%	26,715.96	-100%
15	Зээлийн хүүгийн зардал	0	0.00	0.0%	52,261.03	-100%

3.1 Удирдлагын зардал-ЗАА /Төлөвлөгөө, гүйцэтгэл, өмнөх үетэй харьцуулснаар/


№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь, %	Өмнөх оны гүйцэтгэл	Өсөлт бууралт, %
16	Албан томилолтын зардал	0	0.00	0.0%	18,647.35	-100%
17	Баталгаат засварын зардал	18,182	5086.96	25.1%	29,862.02	-85%
18	Хандив тусламжийн зардал	0	1,452.0	100%	0	100%
19	Найдваргүй авлагын зардал	37,174.84	37,174.84	100.0%	37,174.84	0%
20	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардал	91,730.01	127,061.89	138.5%	109,752.98	16%
21	Бусад зардал /Үйл ажиллагааны бус зардал/	-	9,223.86	100.0%	55,978.79	-84%
ДҮН		928,861.24	771,750.81	83.09%	1,039,743.55	-26%

3.1 Удирдлагын зардал /Төлөвлөгөө, гүйцэтгэл, өмнөх үетэй харьцуулснаар/



3.2 Удирдлагын зардал-ТУЗ /Төлөвлөгөө, гүйцэтгэл, өмнөх үетэй харьцуулснаар/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь, %	Өмнөх оны гүйцэтгэл	Өсөлт бууралт, %
1	ТУЗ-ын цалин, НДШ-ийн зардал	104,146.08	100,802.40	96.8%	98,563.79	2%
2	ТУЗ-ын үйл ажиллагааны зардал	42,067.27	30,611.58	72.8%	31,529.10	-3%
ДҮН		146,213.35	131,413.98	89.9%	130,092.89	1%



4. Ашиг, алдагдал /Санхүүгийн тайлангаар/

№	Үзүүлэлт	Өмнөх он 2024	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь, %
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,236,537.89	4,091,198.18	948,345.30	23.18%
2	Борлуулалтын өртөг	1,132,522.39	2,173,872.91	738,840.70	33.99%
3	Нийт ашиг (алдагдал)	1,104,015.50	1,917,325.27	209,504.60	10.93%
4	Хүүгийн орлого	180.89	0	0	0.00%
5	Ерөнхий ба удирдлагын зардал	986,075.48	1,075,074.59	903,164.79	84.01%
6	Бусад зардал	5,614.87	0	0.00	0.00%
7	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(-0.01)	0	0	0.00%
8	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0	0	0.00%
9	Бусад ашиг (алдагдал)	-103,505.24	0		0.00%
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	9,783.52	842,250.68	-693,660.19	-82.36%
11	Орлогын татварын зардал	16,368.16	84,225.07	0.00	0.00%
12	Татварын дараах ашиг (алдагдал)	-6,584.64	758,025.61	-693,660.19	-91.51%

5.1 Авлагын өсөлт, бууралт

№	Авлагын төрөл, ангилал	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Төлөгдсөн	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралтын хувь%,
1	Байгууллагаас авах авлага	404,843.13	49,316.86	240,909.01	213,250.98	-89.84%
2	ХХ-тай байгууллагаас авах авлага	275,265.48	95,696.29	820.20	370,141.57	25.63%
3	Хувь хүмүүсээс авах авлага	28,966.87	0.00	0.00	28,966.87	0.00%
4	Ажилчдаас авах авлага	0.00	10,106.51	470.85	9,635.67	100.00%
5	Баталгааны авлага	368,937.23	0.00	8,258.27	360,678.96	-2.29%
6	Дараа тайлангаар тооцоо	9,414.48	33,078.85	38,000.62	4,492.72	0.00%
7	Шатахууны тооцоо	154.30	4,380.63	4,507.04	27.89	-453.25%
ДҮН		1,087,581.50	192,579.14	292,965.98	987,194.66	-10.17%

Тайланд онд Юнайтед конкрет ХХК-ний 187,2 сая, Жижиг хийц ХХК-ний 11,9 сая төгрөгийн авлага төлөгдөж, нийт авлага эхний үлдэгдлээс 10.17%-иар буурсан байна.

5.2 Өглөгийн өсөлт, бууралт

№	Өглөгийн төрөл, ангилал	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Төлөгдсөн	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралтын хувь%,
1	Байгууллагад төлөх өглөг	339,539.03	278,140.92	204,624.91	413,055.04	17.80%
2	ХХ-тай байгууллагад төлөх өглөг	2,006,462.80	158,406.63	95,007.11	2,069,862.32	3.06%
3	Хувь хүмүүст төлөх өглөг	755,070.50	184,225.59	344,124.52	595,171.57	-26.87%
4	Ажилчдад өгөх өглөг	0.00	2,998.35	0.00	2,998.35	100.00%
5	Ногдол ашгийн өглөг	122,784.23	0.00	0.00	122,784.23	0.00%
6	Барьцаа төлбөрийн өглөг	161,369.10	0.00	0.00	161,369.10	0.00%
7	ҮЭ шимтгэлийн өглөг	6,796.69	0.00	0.00	6,796.69	0.00%
8	Татварын өглөг	1,102,218.40	188,097.30	73,952.12	1,216,363.58	9.38%
9	НДШ-ийн өглөг	49,561.20	116,352.82	5,704.80	160,209.22	69.06%
ДҮН		4,543,801.95	928,221.61	723,413.46	4,748,610.11	4.31%

Тайланд онд Ав шүтээн ХХК-д 14,0 сая, Тэнүүн өлзий ХХК-д 8,0 сая, Их дөрөлж өргөө ХХК-д 11,4 сая, Ган хийц сендвич хавтангийн үйлдвэр ХХК-д 38,3, Эко цаг ХХК-д 63,04 сая, М.Даваасүрэнд 27,3сая төгрөгийн өглөг үүсч, нийт өглөг эхний үлдэгдлээс 4,3%-иар өссөн байна.

5.3 Татварын өглөгийн өсөлт, бууралт

№	Өглөгийн төрөл, ангилал	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Төлөгдсөн	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралтын хувь%,
1	Орлогын татварын өглөг	56,314.262	0.00	2,528.00	53,786.26	-4.49%
2	ХАОАТ-ын өглөг	95,470.95	50,387.57	8,360.00	137,498.52	44.02%
3	Газрын татварын өглөг	19,184.64	23,610.02	0.00	42,794.66	123.07%
4	ҮХ хөрөнгийн албан татварын өглөг	0.00	6,024.99	0.00	6,024.99	100.00%
5	Татварын алданги торгуулийн өглөг	49,755.78	0.00	0.00	49,755.78	0.00%
6	Бусад татварын өглөг	0.00	915.64	915.64	0.00	0.00%
7	НӨАТ-ын өглөг	881,492.80	45,010.61	0.00	926,503.41	5.11%
ДҮН		1,102,218.43	125,948.83	11,803.64	1,216,363.62	10.36%

Тайлант онд ОАТ-2,5 сая, ХХОАТ-8,4 сая, бусад татвар-0,9 сая, нийт 11,8 сая төгрөгийн татвар төлж, 125,9 сая төгрөгийн татварын өр төлбөр үүсч татварын өр төлбөрийн эцсийн үлдэгдэл оны эхний үлдэгдэлтэй харьцуулахад 10,3%-иар өссөн байна.

7. Дүгнэлт

1. Ган хийц ХК нь 2025 онд 693,6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. Алдагдалтай ажиллагаанд нөлөөлсөн гол хүчин зүйлс нь:
 - Борлуулалтын орлого төлөвлөсөн түвшинд хүрээгүй буюу гүйцэтгэл 23,1%,
 - Нийт борлуулалтын орлогын 40,1%-ийг бүрдүүлэхээр төлөвлөсөн Үйлдвэрийн борлуулалтын орлогын гүйцэтгэл 34,5%,
 - Нийт борлуулалтын орлогын 44,4%-ийг бүрдүүлэхээр төлөвлөсөн Төслийн борлуулалтын орлогын гүйцэтгэл 0%
 - Борлуулсан бүтээгдэхүүний өртөгийн орлогод эзлэх хувь 77,91% буюу, төлөвлөсөн түвшнөөс 46,6%-иар өссөн зэрэг үзүүлэлтүүд алдагдалтай ажиллахад гол нөлөө үзүүлж байна.
 - Ерөнхий удирдлагын зардлын хувьд төлөвлөсөн түвшнөөс 16%-иар бууруулж ажилласан.
2. Үйлдвэрлэлийн борлуулалтын орлого гүйцэтгэл хангаагүй шалтгаан нь:
 - МАКРО түвшний хувьд зах зээлийн нөхцөл байдал, төмөр хийц үйлдвэрлэлийн салбарын БНХАУ-аас өндөр хамааралтай байдал, улс төрийн нөхцөл байдал, татварын дарамт зэргээс,
 - МИКРО түвшний хувьд үйлдвэрлэлийн ашиглалтын зардал, ажиллах хүчний ур чадвар, хөдөлмөрийн бүтээмж, тоног төхөөрөмжийн хүчин чадал зэрэг гол нөөцүүд хангалтгүй байгаа нь нэгж бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөгийг өсгөж импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөх боломжийг хязгаарлаж байна.
3. Төслийн борлуулалтын орлого гүйцэтгэл хангаагүй шалтгаан нь:
 - Компани татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн их хэмжээний өртэй, банкин дахь харилцах дансуудаа хаалгасан зэрэг нь санхүүгийн үйл ажиллагааг эрсдэлд оруулж улсын болон хувийн хэвшлийн байгууллагаас зарласан тендер, худалдан авах ажиллагаанд оролцох боломжийг хязгаарлаж байна. Үүний улмаас борлуулалтын боломж хумигдаж, зах зээлийн байр суурь сулрах, цаашид орлогын эх үүсвэр буурах эрсдэл үүсэж байгаа тул уг асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх шаардлагатай байна.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

ГАН ХИЙЦ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮНИЙ АНКЕТ

I. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Овог нэр: Түмэнжаргал
2. Өөрийн нэр: Буяннэмэх
3. Төрсөн Он, сар, өдөр: 1983.11.14
4. Төрсөн аймаг, хот: УБ хот
5. Гэр бүлийн байдал /Зөвхөн ам бүлд байгаа хүмүүсийг бичнэ/



Таны юу	Овог нэр	Төрсөн он, сар, өдөр	Төрсөн аймаг, хот, сум	Одоо эрхэлж буй ажил	Утас
Эхнэр	Ч. Уянга	1985	Увс	Үсчин	
Охин	Б. Амин-Эрдэнэ	2009	УБ	Сурагч	
Охин	Б. Эгшиглэн	2013	УБ	Сурагч	
Хүү	Б. Төгөлдөр	2015	УБ	Сурагч	

II. БОЛОВСРОЛ /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн онгоо	Эзэмшсэн мэргэжил, диплом, гэрчилгээний дугаар, эрдмийн зэрэг цол
ТЕГ дээд	УБ	2002	2005	Эрх зүйч
HSE-сургалт	УБ	2010		ХАБЭА

III. АЖИЛ ЭРХЛЭЛТ /Одоо хийж буй ажлаас эхлэн бичнэ/

Албан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
Эко цаг ХХК	ХАБЭА инженер	8 жил

IV. БУСАД

Гэрийн хаяг: СХД-ийн 34-р хороо Буман Өлзий 755-р байр

Утасны дугаар:

Гар утас: 94117338

Регистрийн дугаар:

Ц	Д	8	3	1	1	1	4	9	7
---	---	---	---	---	---	---	---	---	---

Гарын үсэг /баталгаат/:*Т. Буяннэмэх*.....

Огноо:/.../....

ГАН ХИЙЦ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮНИЙ АНКЕТ

I ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Овог нэр: Сайнбилэг
2. Өөрийн нэр: Лхамцэрэн
3. Төрсөн Он, сар, өдөр: 1998.10.12
4. Төрсөн аймаг, хот:
5. Гэр бүлийн байдал /Зөвхөн ам бүлд байгаа хүмүүсийг бичнэ/



Таны юу	Овог нэр	Төрсөн он, сар, өдөр	Төрсөн аймаг, хот, сум	Одоо эрхэлж буй ажил	Утас
Охин	М. Арууханхур	2021	Увс		

II БОЛОВСРОЛ /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн онгоо	Эзэмшсэн мэргэжил, диплом, гэрчилгээний дугаар, эрдмийн зэрэг цол
МУИС-харьяа ХОИС	Ховд аймаг	2016	2020	Бакалавр
МУИС	УБ	2022	2023	Магистр

III АЖИЛ ЭРХЛЭЛТ /Одоо хийж буй ажлаас эхлэн бичнэ/

Албан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
БЗӨБЦТС ТӨХК	Төслийн ажилтан	2 жил
Монполимет групп	Захиргаа, Хүний нөөцийн ажилтан	1 жил
Ган Хийц ХК	Хүний нөөцийн менежер	1 жил 5 сар

IV БУСАД

Гэрийн хаяг: ХУД 24р хороо, шинэ өргөө хороолол 620р байр 31 тоот

Утасны дугаар:

Гар утас: 96002297

Регистрийн дугаар:


О К 9 8 1 0 1 2 2 3

Гарын үсэг /баталгаат/:

ГАН ХИЙЦ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮНИЙ АНКЕТ

I ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Овог нэр: Зориг
2. Өөрийн нэр: Алтанхуяг
3. Төрсөн Он, сар, өдөр: 1991.03.01
4. Төрсөн аймаг, хот:
5. Гэр бүлийн байдал /Зөвхөн ам бүлд байгаа хүмүүсийг бичнэ/



Таны юу	Овог нэр	Төрсөн он, сар, өдөр	Төрсөн аймаг, хот, сум	Одоо эрхэлж буй ажил	Утас
Эхнэр	Д.Болормаа	1985	Дархан аймаг		
Охин	А.Оюун	2022	УБ хот		

II БОЛОВСРОЛ /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн онгоо	Эзэмшсэн мэргэжил, диплом, гэрчилгээний дугаар, эрдмийн зэрэг цол

III АЖИЛ ЭРХЛЭЛТ /Одоо хийж буй ажлаас эхлэн бичнэ/

Албан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
Эко цаг ХХК	инженер	2013 оноос хойш

IV БУСАД

Гэрийн хаяг: ХУД, 26-р хороо
 Утасны дугаар: 88060870

Регистрийн дугаар:

У П 9 1 0 3 0 1 1 9

Гарын үсэг /баталгаат/: З.Алтанхуяг
 Огноо:/...../.....